

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТАЙЛАН

Сэдэв: Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт

2024 оны 11 дүгээр
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т “Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг тухайн асуудал эрхэлсэн Байнгын, дэд хороо хэлэлцэн хүлээн авсан, Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлэг хүсэлт гаргасан, эсхүл Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулна.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 22 гишүүнээс Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгаланд хандан 2024 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн УИХ-03/1114 дүгээр албан бичиг ирүүлсэн бөгөөд уг албан бичигт түр болон албадан саатуулагдаж, цагдан хоригдож буй иргэд, ял эдэлж буй хоригдлууд, хугацаат цэргийн алба хаагчдын амь нас, бие махбод, сэтгэл санаатай холбоотой хүний эрхийн зөрчлүүд хууль сахиулах болон батлан хамгаалах байгууллагуудад удаа дараа гарч, төрийн зарим албан тушаалтнууд холбогдож байгаа асуудлыг дурдсан.

Түүнчлэн хэвлэл, мэдээллийн болон бусад салбар дахь хүний эрхийн төлөв байдал, зөрчлийн талаар олон нийтэд сонсох, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх, ёс зүй, хариуцлагын механизмыг сайжруулах, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байх тул Улсын Их Хурлаас хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлт гаргасан.

Энэхүү хүсэлтийг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, 02 дугаар тогтоолыг баталж, “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийг томилсон.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.2 дахь хэсэгт заасны дагуу хяналтын сонсгол болох талаарх тов, мэдээллийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 15-ны өдрийн 17.30 цаг хүртэл олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сонсголд оролцогчдыг бүртгэсэн.

2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Төрийн ордны “Эзэн хаан Чингис хаан” танхимд “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” сэдвийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг зохион байгууллаа.

Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч П.Сайнзориг нээж, сонсгол зохион байгуулах болсон үнлэснэл, сонсголын зорилго, оролцогчдын ирц.

сонсголын дэг, дараалал, сонсголд оролцогчдын эрх, үүргийг танилцуулснаар эхэлсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасны дагуу Хууль зүйн байнгын хорооны 22 гишүүнээс 15 хүрэлцэн ирж, хуулийн дагуу сонсголын ирц бүрдсэн болно.

Сонсголд Улсын Их Хурлын гишүүдээс гадна төрийн байгууллагыг төлөөлж 37 албан тушаалтан, 122 иргэн, хуулийн этгээд оролцогчоор бүртгүүлснээс 85 оролцогч хүрэлцэн ирсэн бөгөөд цахимаар 2 оролцогч оролцсон. Мөн сонсголд 2 иргэн ажиглагчаар бүртгүүлж, оролцлоо.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.4-т заасны дагуу “Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулж болох бөгөөд хувь хүн, хуулийн этгээд, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоос бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно” гэж заасны дагуу сонсголыг нээлттэй явуулсан бөгөөд хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах, тэдний сонсголд оролцох, ажиглах боломжийг хангаж, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз болон парламентын шууд дамжуулах суваг, телевизийн Тэнгэр-тв, NTV, Eagle, ТМ сувгуудаар сонсголыг дохионы хэлмэрчтэй шууд дамжууллаа news.mn, itoim.mn, eguur.mn, ubn.mn, livetv.mn, zogii.mn, tsahiur.mn tur.mn, tug.mn, ivoice.mn, ikon.mn, gogo.mn ergelt.mn, zarig.mn зэрэг мэдээллийн цахим хуудсаар олон нийтэд мэдээллээ.

Сонсголын дүгнэлт, мэдээлэл сонсох эхний хэсэгт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т “Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүний санаачилснаар хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол явуулах бөгөөд Хүний эрхийн Үндэсний Комиссоор дүгнэлт гаргуулна.” гэж заасны дагуу “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандалтаас ангид байх эрхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хийсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дүгнэлт”-ийг танилцуулсан.

Мөн холбогдох чиг үүргийн байгууллага, албан тушаалтны дараах мэдээллийг танилцуулсан:

1. Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандалтаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын мэдээллийг Хууль зүй, Дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нь Н.Мягмар;
(Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ээс үзнэ үү.)
2. Эрүү шүүлт болох гэмт хэргийн одоо шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг Улсын ерөнхий прокурорын орлогч прокурор М.Чинбат;
(Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-оос үзнэ үү.)
3. Эрүү шүүлт эрүүдэн шүүх гэмт хэргийн шүүхийн шийдвэрлэлт ба гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэцийн хор уршгийн зэрэглэл тогтоох, нөхөн төлүүлэх, одоо талаарх хууль тогтоомжийн хэрэглээ шүүхийн практикийн талаарх мэдээллийг Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим хариуцсан ахлах референт М. Хатанзориг;
(Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 3-аас үзнэ үү.)

Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийг хангахтай холбоотой асуудлаар дараах мэдээллийг холбогдох байгууллагууд танилцуулсан:

1. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллагад хүний эрх, эрх чөлөөг зөрчих, дүрмийн бус харилцааны талаар гаргасан гомдол, мэдээллийн шийдвэрлэлт болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг Зэвсэгт хүчний жанжин штабын дарга С.Ганбямба;
(Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 4-өөс үзнэ үү.)
2. Төрөлжсөн асрамжийн газарт амьдарч буй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн эрхийн хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул;
(Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 5-аас үзнэ үү.)
3. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлэгчид болон байнгын асруулагчдын эрхийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат.
(Танилцуулгын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 6-аас үзнэ үү.)

СОНСГОЛД ОРОЛЦОГЧДООС ИЛЭРХИЙЛСЭН САНАЛ, МЭДЭЭЛЭЛ, ДҮГНЭЛТ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.4-т заасны дагуу “оролцогчийн санал, мэдээлэл, дүгнэлтээ танилцуулах хугацаа 10 минутаас илүүгүй байх” гэж заасны дагуу сонсголд оролцогчдоос нийт 41 оролцогч санал, дүгнэлтээ илэрхийлсэн.

Оролцогчдын гаргасан санал, мэдээлэл, дүгнэлтийг тоймлон авч үзвэл:

- Эрүү шүүлт гэдэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчсөн хууль хяналтын байгууллагын албан хаагчдын асуудал бөгөөд үүнийг таслан зогсоохын тулд төрийн албан хаагчид өөрсдөө хуулиа хэлбэрэлтгүй мөрдөх шаардлагатай талаар.

- Эрүү шүүлт гэдэг эрүүгийн байцаан шийтгэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой, түүнийг зөрчсөн үйлдэл учраас хүн өөрийнхөө эрүү шүүлтэд өртсөн тухай гомдлоо Хүний эрхийн Үндэсний Комисст гаргах эрхийг нээж өгөх. Энэ нь эрүү шүүлттэй тэмцэнэ гэдэг нь эрүүдэн шүүгээд байгаа хүмүүсийн тухай гомдлыг л хүлээж авах тухай асуудал. Гэтэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гомдлыг Хүний эрхийн Үндэсний Комисс хүлээж авахгүй гээд заачихсан. Мөн хуульд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлнэ гээд заачихсан. Хүний эрхийн Үндэсний Комисс бусад байгууллагуудад хүний эрх зөрчсөн, байцаан шийтгэх ажиллагаа зөрчсөн гомдлыг хүлээж авах боломжийг хуульчилж өгөх талаар.

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулдаг байгууллагуудын тухайд цагдаагийн байгууллагыг бие дааж шийдвэр гаргадаг болгож, прокурорын байгууллага зөвхөн хяналт тавимаар байна. Өнөөдөр прокурорын байгууллага хяналт тавих биш шийдвэр гаргагч болчихсон нь Үндсэн хуулийн зөрчил үүсэж байгааг өөрчлөх шаардлагын талаар.

- Өмгөөлөх эрхийг чөлөөлөх шаардлагатай байна. Хүн хүссэн хүнээрээ өмгөөллийн, хууль зүйн туслалцаа авдаг болох. Зөвхөн хууль зүйн туслалцаа гэхгүй тусгай мэргэжлийн эмч хүнээс, эдийн засагч хүнээс туслалцаа авдаг боломжийг хуульчлах шаардлагатай талаар.

- Шүүх бүрэлдэхүүнд ард түмний төлөөллийг оролцуулдаг болох хэрэгцээ, шаардлагын талаар.

- Хэн нэгэн хүнд хэрэг хүлээлгэх нотлох баримтыг өөрөөр нь гаргуулан авах гэм буруутай гэдгийг нь хүлээн зөвшөөрүүлэх, түүнийг нь өөрийнх нь эсрэг ашиглах ял хариуцлага хүлээлгэх гэсэн агуулгыг илэрхийлдэг. Энэ агуулгыг нэг илэрхийлэхдээ янз бүрийн арга хэрэгсэл хэрэглэдэг. Хүнийг хилсээр шийтгэсний үр дагавар нь тухайн иргэний гэр бүлд хэзээ ч, юугаар ч нөхөшгүй улс төрөөс ямар нөхөн олговор олгоод ч засаггүй нийгмийн хор уршиг учирдаг учраас холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулж мөрдүүлэх шаардлагатай талаар.

- Эрүүдэн шүүлтээс ангид байх, хүний эрхийг хэрэгжүүлэхэд юуны өмнө төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдэх асуудалд онцгой анхаарах, ингэснээр эрүүдэн шүүлтийг шат шатдаа таслан зогсоох боломжтой талаар, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурлын үндсэн зорилт ард түмний засаглах эрхийг хангахад оршино гээд заасны дагуу ард түмэн засаглах эрхээ хэрэгжүүлж байгаагийн нэг тод илэрхийлэл нь өргөдөл, гомдлоо хуулийн дагуу шийдвэрлүүлж чаддаг байх бөгөөд өнөөдөр дийлэнх иргэд өргөдөл, гомдлоо хуулийн дагуу шийдвэрлүүлж чадахгүй хад мөргөөд гацдаг талаар, илт хууль бусаар шийтгэл оногдуулж, зөрчигдсөн эрхийг хуулийн дагуу сэргээн эдлүүлэхгүй байх нь эрүүдэн шүүхээс ялгаагүй байгаа нөхцөл байдлын талаар.

- Улсын дээд шүүх нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй, хуулийг хэрэглэхгүй гэсэн заалтаа зөрчиж өөрийн гаргасан үндэслэл бүхий хуулийнхаа зүйл, заалтын дагуу шийдвэрлэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дэх зүйлийн 1.4-т хэргийн зүйлчлэлд ялыг хүндрүүлэхгүйгээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулна гэснийг зөрчиж, шийдвэр гаргаж байгаа талаар.

- Гадаад улсад амьдарч байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах шаардлагатай талаар, гадаад улс оронтой эрх зүйн гэрээ байгуулаагүй учир тэр улсад амьдарч байгаа иргэдийнхээ амь нас, хууль ёсны эрх ашгийг хамгаалж чадахгүй, үүнээсээ болж гадаад улсад амьдарч байгаа манай улсын иргэд маш их хохирч байгаа талаар, үнэнийг хэлж байгаа хүний эрхийг хамгаалах хууль байхгүй учир манай улсад үнэнийг ярих хүн байдаггүй, шүгэл үлээгчийн хуулийг яаралтай хэлэлцэн батлах шаардлагатай талаар.

- Эрүүдэн шүүнэ гэдэг бол төрийн албан хаагчдын эс үйлдэл бөгөөд ажлаа хийж чадахгүй, эсхүл өс хонзонгоор л хүнийг эрүүдэн шүүдэг талаар, манай улсын хууль тогтоомж иргэдийн эрх ашгийг зөрчсөн, авлигал ашиг сонирхлыг өдөөсөн заалтууд их байдаг талаар, эрх ашиг нь зөрчигдсөн иргэд Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргадаг боловч Комисс ажлаа хангалтгүй хийдэг талаар.

- Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүний эрхийн Үндэсний Комисс эрүүдэн шүүлтийн асуудлыг онцгой анхаарах шаардлагатай талаар, Үндсэн хууль, Монгол Улсын

талаар, Монгол Улсад хууль тогтоомж, дүрэм нь байдаг ч ажил хариуцаж байгаа албан тушаалтнууд нь ажлаа хийж чадахгүйгээс болоод өнөөдөр эрүүдэн шүүлтийн асуудал яригдаж байгаа талаар.

- Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурлын онцгой анхаарах шаардлагатай талаар.

- Хууль зөрчсөн иргэдийг хорих нь шийдвэрлэх арга зам мөн эсэх талаар, Үүнээс урьдчилан сэргийлж байгаа арга хэмжээ байгаа эсэх, энэ талаар олон улсын жишгийг харах шаардлагатай талаар, хар тамхи хэрэглэсэн хүнийг шууд эрүүдэн шүүгээд ялтан гэж үзээд шоронд хийх нь зөв гарц гаргалгаа мөн эсэх, тэдгээр хүмүүсийг нийгэмшүүлэх нь зөв гарц гаргалгааны талаар.

- Зоригийн гэх хэрэгтэй холбогдуулан Монгол Улсын дээд шүүх, Монгол Улсын прокуророос хэргийг нотлох баримтгүй, хэрэгсэхгүй болоод тогтоол, шийдвэрүүд нь гарчихсан байхад Улсын Их Хурлын гишүүн нь өнөөдөр ард түмэнд ташаа мэдээлэл өгөөд байж байгаа нь Улсын Их Хурлын гишүүн болонгуутаа дураараа хэн нэгний эрхэд халдаад хэн нэгний нэр төрийг гутааж байгаа талаар, эрүүдэн шүүлт Монгол Улсын шүүхээр өнөөдөр үргэлжилж байгаа бөгөөд эрүүдэн шүүсэн гэмт хэргийн нөхөн төлбөрийн асуудлыг өнөөдрийг хүртэл шийдвэрлэж өгөхгүй байгаа тул Улсын Их Хурлаас Түр хороо байгуулаад ажиллах шаардлагатай талаар.

- Хүнд ял оногдуулахдаа зөвхөн хохирогчийн нэг талын мэдүүлгээр шийтгэл хүлээлгэж болохгүй талаар, үүний цаана тухайн хүний гэр бүлийн эрх, үр хүүхдийн эрх давхар зөрчигддөг талаар, аливаа хэрэг хянан шийдвэрлэхдээ ЭХХШТХ-ийн 16.2-т заасны дагуу нотловол зохих асуудлыг тал бүрээс нь судалж, яллах, цагаатгах бүх талыг нь бүрдүүлэх дээр нотлох баримтаар эргэлзээгүй байна гэдгийг хангаж л шийдэж байх шаардлагатай талаар.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга нарын дур зоргоороо гаргасан журмуудаас болж хорих анги, цагдан хорих байр, баривчлах байранд байгаа хүмүүсийн эрх зөрчигддөг талаар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг яаралтай шинэчлэн найруулах шаардлагатай талаар.

- Хорих анги, цагдан хорих байр, баривчлах байруудад байгаа камерын дуу дүрсний бичлэгийг нь давхар бичдэг болгох шаардлагатай талаар.

- Орчин цагийн хэлмэгдүүлэлт буюу “хуулийн хонгил”-ын бүрэлдэхүүнд ордог албан тушаалтнуудад хариуцлага тооцох асуудлаар Улсын Их Хурлаас хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулан ажиллах талаар.

- 2011-2016 онуудад улс төр, бизнесийн тодорхой бүлэглэлийн зүгээс төрийн болон иргэдийн өмч хөрөнгийг луйвардах, өс хонзонгоо авах, бусад ашиг сонирхлын үүднээс хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагыг ашиглаж бусдыг хэлмэгдүүлэн хохироох явдал хэрээс хэтэрч Монгол Улсын түүхэнд “хуулийн хонгил” гэх нэршлээр хэлмэгдүүлэлтийн нэгэн хар хуудас болсон. Үүний улмаас олон иргэд амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон. Эдгээр хохирсон иргэд хамтран Эрүүдэн шүүлт хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоог байгуулж, ямар нэг хэлбэрээр үндэслэлгүйгээр цагдан хоригдсон, зохиомол хилс хэрэгт шалгагдаж, эрүүдэн шүүгдсэн, хууль бус нотлох баримтаар хорих ялаар шийтгэгдсэн 47 иргэн орлоодон нэгдсэн. Эдгээр хэлмэгдсэн иргэдийн ар гэр

Авлигатай тэмцэх газарт шалгагдаж, хэвлэл мэдээллээр гүтгүүлж, гутаан доромжлогдож, сэтгэл санаа нь шаналган тарчилсан, шууд бусаар хэлмэгдэж, хууль бусаар хоригдож, эрүү шүүлтэд өртсөн 200 гаран иргэн дэмжин ажилладаг. Иймд “хуулийн хонгил”-ын улмаар хэлмэгдсэн иргэдийн асуудлыг Улсын Их Хурлаас шалгах зэрэг асуудлыг тус тус сонсголд ороцлогчдийн зүгээс санал, хүсэлт, мэдээллэл гарлаа.

ДҮГНЭЛТ, ТАНИЛЦУУЛГА, МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДИЙН АСУУЛТ, ХАРИУЛТ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.5-д “*гишүүн оролцогчоос асуулт асуух, хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно.*” гэж заасны дагуу сонсголд оролцсон Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Ц.Сандаг-Очир, Г.Ганбаатар, Х.Баасанжаргал, Ж.Баярмаа, О.Номинчимэг, М.Нарантуяа-Нара, С.Эрдэнэболд, Д.Цогтбаатар нарын гишүүд асуулт асууж, холбогдох албан тушаалтнаас хариулт авлаа.

Асуулттай холбогдуулан Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар зэрэг байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтнаас гадна сонсголд оролцогчид хариулт өгсөн болно.

Асуулт асуусан Улсын Их Хурлын гишүүдийн асуултыг тоймлон авч үзлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан:

1/Хүний эрхийн зөрчил хууль хяналтын байгууллага, хүчний байгууллагын албан хаагчдаас үүдэлтэй асуудлууд байна. Тэгэхээр мөрдөн байцаах үйл ажиллагаанд саад учруулах эрхийг Хүний эрхийн Үндэсний Комисст өгвөл яасан юм бэ? Хэрвээ эрх нь зөрчигдсөн иргэн зөрчигдсөн эрхийн талаарх гомдлоо Хүний эрхийн Үндэсний Комисст өгсөн тохиолдолд түүнийг таслан зогсоох, шалгах эрхийг өгч, улмаар энэ байгууллагын эрх мэдлийг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

2/Хүний эрхийн Үндэсний Комиссын 7 гишүүнийг Улсын Их Хурлаас сонгодог биш ард түмнээс сонгодог, эргээд хяналт тавьдаг болох.

3/ Хүчний байгууллагын дарга нарыг нэг хүний гарын үсгээр томилдгоос татгалзаж, мэргэжлийн хүмүүсийн дунд нээлттэй сонгон шалгаруулалтаар томилдог болох боломжийг судлах.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир:

1/Өнөөдрийн сонсголоос гарах үр дүн юу юм бэ?

2/Манай мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд харилцан нэг нэгнээ шалгах ийм хууль, журам үйлчилж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль энэ ерөнхий прокурорын дагаж гаргасан энэ журмыг хэзээ өөрчлөх юм бэ?

3/Хууль зүйн байнгын хорооны даргын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Прокурорын байгууллагад хуралдсан Монгас интернэйшнл компанийн захирал

Ганболд иргэний гаргасан гомдол 3 шатны шүүхээр шийдэгдээд өнөөдрийг хүртэл шүүхийн шийдвэр хэрэгжихгүй байгаа асуудалд Улсын Ерөнхий прокурорын байгууллагаас баримтлаж буй байр суурь ямар байна вэ?

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар:

1/Хүнийг эрүүдэн шүүж хохироосон нэр бүхий албан тушаалтнууд одоо хүртэл албаа хашиж байна. Хүний эрхийг удаа дараа зөрчсөн албан тушаалтнууд яагаад одоо болтол хоорондоо албан тушаалаа сэлгүүлээд ажиллаад байдаг юм бэ?

2/Хүний эрх зөрчөөд зөрчсөн албан тушаалтнуудын одоо хар жагсаалт гэж байдаг юм уу? Дата гэж байдаг юм уу? Ажил үүргээ үгүйсгэж чадахгүй компаниудын хар жагсаалт гэж байдаг шүү дээ хүний эрхийг зөрчсөн энэ хуулийн ажилтнууд холбогдох албан тушаалтнууд энэ дээр ямар бодлого чиглэл барьдаг вэ?

3/Нөхөн олговрын санд чинь одоо юм байдаг юм уу? Нийт өнгөрсөн хугацаанд энэ нөхөн олговортой холбоотой ер нь яаж шийдэж ямар аргачлалаар шийдэж ирсэн юм?

4/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар дээр Улсын Их Хурлын сонгуулийн өмнө 421 дүгээр анги дээр хүн толгойгоо таслуулж нас барсныг та нар яагаад нуун дарагдуулсан бэ? Тухайн үед Хүний эрхийн Үндэсний Комисс мэдсэн үү?, Хууль зүй, дотоод хэргийн сайд мэдсэн үү?, мэдсэн бол одоо яагаад энэ тухай ярихгүй байна вэ? Эсвэл Улсын Их Хурлын сонгууль болж байгаатай холбоотой нуун дарагдуулсан уу?

5/ Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны даргын цэргийн хүн гэж хүн байна уу? Энэ хүн шагналаа угааж салхинд гарч явж байгаад согтуурч байгаад нэгийнхээ амь насанд хүрсэн энэ асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн сайд мэдэж байгаа юу?

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал:

1/Хүүхдүүд эрүү шүүлтэд өртсөн тохиолдол танай судалгаагаар гарав уу?

2/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа хэм хэмжээний акт, дүрэм, журмууд дээр эрүү шүүлт үүсгэхүйц нөхцөл байдал байгаа эсэх дээр дүн шинжилгээ хийсэн үү? түүнтэй холбоотой ямар судалгаа баримт байна вэ?

3/Хууль зүй, дотоод хэргийн яамнаас эрүүлжүүлэгдсэн болон саатуулагдсан хүний тоог ялгаж гаргах шаардлагатай байна. Тэр дундаа саатуулагдсан хүмүүсийн шалтгаан, нөхцөл тоо, статистикийн чиглэлийн судалгааг сүүлийн 3 жилийн байдлаар гаргаж өгөөч?

4/Хохирогчид олгож байгаа нөхөн төлбөрийн талаар яг тухайн жилдээ барагдаж чаддаггүй. Одоо шүүхийн шийдвэр нь гарсан боловч эрүү шүүлттэй холбоотой нөхөн төлбөр нь барагдаагүй хэчнээн хүн байгаа вэ? хэчнээн төгрөгийн хохирол байгаа вэ?

5/Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тоолохдоо шүүх...

хугацаанд нь тоолдоггүй байсан нь одоо хүртэл хэвээрээ байгаа. Энэ хуулийн өөрчлөлт хэзээ орох вэ? Цагдан хорих нийт хугацаанд яагаад энэ шүүхийн шийдвэр шүүх рүү хэрэг нь шилжчихсэн байгаа хүний энэ цагдан хорионы хугацаа ордоггүй юм бэ?

6/Гадаад улсад байгаа иргэдийн эрхийг хамгаалах талаар ялангуяа Солонгос Улсад албадан баривчилгаагаар нутаг буцаахаар нөхцөл байдалд манай иргэд ордог. Үүнтэй холбоотой эрүүдэн шүүлтийн нөхцөл байдлууд үүсдэг гэдэг мэдээнүүд байдаг. Үүнтэй холбоотой ямар арга хэмжээ авч байгаа вэ?

7/Эрүү шүүлт гарч болзошгүй гэх тодорхой газрууд байна. Эдгээрийг бүрэн камержуулах тэр дундаа дуу чимээг бичдэг байх талаар Хууль зүйн яамнаас ямар бодлого ямар зүйл баримталж байгаа вэ?

8/Эрүү шүүлтийн хохирогч нэг хүүхдийн талаар Хүний эрхий Үндэсний Комиссын дүгнэлтэд дурдлаа. Үүний шүүхийн шийдвэр ямар түвшинд байгаа, тухайн хүүхдийн нөхцөл байдал ямар байна вэ?

9/Эрүү шүүлт үйлдсэн гэх энэ алба хаагчдын талаарх хариуцлагын талаарх судалгаа хэр оновчтой байгаа талаар тусгайлсан судалгаа байгаа юу?

10/Хугацаат цэргийн алба дээр энэ тоо буурахгүй байгаа шалтгаан нөхцөл юу вэ?

11/Эрүү шүүлттэй холбоотой гэм буруу нь тогтоогдсон этгээдүүд хариуцлага ялын бодлого хэр оновчтой байна гэж та бүхэн харж байна вэ? Үүнтэй холбоотой криминологийн судалгаа байдаг уу?

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа:

1/Прокурорын байгууллага мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих ёстой. Хяналт тавьж байх явцад эрүү шүүлттэй холбоотой хүнлэг бус харилцаатай асуудлуудыг илрүүлсэн тохиолдлууд байна уу? Байдаг бол хэд юм бэ?

2/Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн учраас олон улсын гэрээ конвенцуудад нэгдчихсэн байдаг. Эрүү шүүлтийн эсрэг конвенцод 2014 онд нэмэлт протоколд нь элссэн байгаа. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаагаа сайжруул гэсэн ч урьдчилан сэргийлэх ажиллагаа байхгүй хяналт байхгүй явж байгаад олон хүний эрхийн зөрчил, эрүү шүүлттэй холбоотой асуудлууд үүсдэг. Тэгээд арга хэмжээгээ ч авч чадахгүй өдий хүрээд ирчихсэн. Урьдчилан сэргийлэх ажиллагаа яаж явагддаг юм бэ?

3/Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх энэ ажиллагаа нь өөрөө хараат бусаар үр дүнтэй хэрэгжихэд бэрхшээл хүндрэл тулгарч байна гээд дүгнэчихсэн байна. Энэ яагаад байгаа юм бэ? ямар хүндрэл үүсээд байгаа юм бэ?

4/Цэргийн ангитай холбоотой дүрмийн бус харилцаа өнөөг хүртэл буурахгүй байгаа гол шалтгаан нөхцөл нь юу дээр байна вэ? 21 настай талийгч залуугийн хэрэг юу болсон бэ? Одоо хүртэл юу болж байгаа нь тодорхойгүй энэ ямар нэгэн ажилтан хариуцлага хүлээх тийм нөхцөл байдал үүссэн үү үүсээгүй юм уу?

5/Төрийн шийдвэрээр эрхийг нь хязгаарлачихаад амь настай холбоотой асуудлууд үүсээд байгаа нь өөрөө болж байгаа юм уу?

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг:

1/Өнөөдөр олон хүмүүс ирээд эрүүдэн шүүгдсэн хилс хэргээр хэрэг хүлээсэн үүнийхээ дагуу хохирлоо нөхөн төлүүлэх гээд системтэй тулаад үүнийгээ шийдвэрлүүлж чадахгүй байгаа тухай хэлж байна. Эрүүдэн шүүлтийн эсрэг конвенцод нэгдэж орсон. Энэ конвенцын 14 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө гэсэн байгаа юм. Тэгэхээр энэ чинь эрүүл мэндээрээ бүх л юмаараа хохирчихсон хүмүүс үүнийгээ заавал авхуулах эрх зүйн орчинтой байх ёстой гэдгийг энэ конвенцоор манай Монгол Улс бол хүлээн зөвшөөрчихсөн байгаа юм. Гэтэл Хүний эрхийн Үндэсний комиссоос хохирогчид нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагаа дутмаг, процессын олон үе шатыг дамжиж, ач холбогдолтой нотлох баримт гаргуулах явцад олон саад бэрхшээлтэй учирдаг учраас нөгөө хохирогчид маань давхар давхар хохироод байна гэсэн дүгнэлтийг хийсэн байна. Хариуцлага нь торгууль байсан боловч иргэний журмаар шийдвэрлэгддэг үү? Хууль зүй, дотоод хэргийн яамны сангаас нэг ч төгрөг гаргаж авч чадаагүй гэсэн үг юм уу? Хохирогч төрөөс иргэний журмаар нэг ч төгрөг энэ 14 хэргийн хохирогч мөнгө төгрөг төлбөр хохирлоо гаргаж аваагүй гэсэн үг үү?

2/Прокурорын байгууллага Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.1-ээр төр нийтийн ашиг сонирхлоор зөрчилдсөн гэж үзэх юм бол төрийн байгууллагын хүсэлтээр эсвэл өөрийнхөө санаачилгаар төрийн нэрийн өмнөөс оролцох ёстой байдаг. Ялангуяа эрүү шүүлттэй холбоотой асуудал дээр хохирогчид нөхөн төлбөрөө төлүүлбэ, хохирлоо барагдуулья, нэр төрөө сэргээе гээд шүүхэд хандахад прокурор 14 хэргийн хэд дээр нь төрийг төлөөлж нийтийн эрх ашиг зөрчигдөж байна, хүний эрх ашиг зөрчигдсөн байна гэж хэрхэн үзэж оролцсон юм бэ?

3/Хүний эрхийн Үндэсний комиссын дүгнэлт дээр энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхдээ төрийн нууц, гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагаагаар халхавчлах хандлага гарч ирж байгаа нь хор уршгийн хувьд илүү ноцтой илрүүлэх, нотлох, хяналт тавих, шүүхээр эцэслэн шийдвэрлэхэд хүндрэл учруулж байна гэсэн байна. 2012-2016 оны үед гарсан хэргүүдийн хохирогчдын яриа дээр гарсан. Яаж ял наймаалцах байдлаар ингэж хийсвэр хэрэгт гүтгэдэг вэ? Тэгэхээр үүнийг задлахын тулд дахиж ийм хэрэг гаргахгүйн тулд Гүйцэтгэх ажиллагааны тухай хууль, Төрийн нөөцийн тухай хууль дээрээ Хууль зүй, дотоод хэргийн яам ямар бодлого барьж, хэзээ энэ талаар өөрчлөлт шинэчлэлд оруулах бодлогыг барьж байгаа вэ?

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара:

1/М.Хувцагаан өмгөөлөгчийн хохирогчийн ял тулгасан цагдаа нарт ямар арга хэмжээ авсан юм бэ? Мөн энэ тал дээр Хүний эрхийн Үндэсний комисс хэлмэгдсэн хүн дээр ямар арга хэмжээ авсан бэ? Мөнгөн дүн 50 сая төгрөгийг нь та бүхэн бас юу гэж үнэлсэн юм бэ?

2/21 настай залуу нас барчихсан, мөн хилс хэрэгт холбогдсон иргэн Л.Гансүх, Д.Энхбат, Б.Жаргал гээд хүмүүс байгаа. Эдгээр иргэд үүрэгт ажлаа хийж байгаад эрх бүхий албан тушаалтны буруутай үйлдлээс болж өөрийнхөө ажил үүргийн хүрээнд тогтоосон ажлаа хийснийхээ дагуу хонгилоор чирэгдсэн байж байгаа. Төрийн эрхийн хохирогчид нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагаа дутмаг, процессын олон үе шатыг дамжиж, ач холбогдолтой нотлох баримт гаргуулах явцад олон саад бэрхшээлтэй учирдаг учраас нөгөө хохирогчид маань давхар давхар хохироод байна гэсэн дүгнэлтийг хийсэн байна. Хариуцлага нь торгууль байсан боловч иргэний журмаар шийдвэрлэгддэг үү? Хууль зүй, дотоод хэргийн яамны сангаас нэг ч төгрөг гаргаж авч чадаагүй гэсэн үг юм уу? Хохирогч төрөөс иргэний журмаар нэг ч төгрөг энэ 14 хэргийн хохирогч мөнгө төгрөг төлбөр хохирлоо гаргаж аваагүй гэсэн үг үү?

3/Иргэн Д.Энхбатаас асуумаар байна. Та эрүүдэн шүүлгэчихсэн өчнөөн ноцтой зүйлүүдийг яригдаж байна. Та эрүүдэн шүүсэн гомдлоо холбогдох газарт нь өгсөн үү? Арга хэмжээ авсан байгаа юу? Тэгээд дахиад давхар эрүүдэн шүүх хүнийг хэлмэгдүүлэхийг хэн хийж чадах вэ?

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд:

1/Ямар нэгэн улс төрч Монгол Улсын төрийн өндөр албан тушаалтан тодорхой хэргийг зорилготойгоор чиглүүлэх, залуурдах, хэргийн үйл явцад чиглэл өгөх шүүхэд тухайн субъектийг шалгагдаж байгаа субъектийг ч юм уу, тэгж яллаарай гэдэг чиглэл өгдөг зүйл байна уу? Монголын томоохон улс төрчид төрийн өндөр албан тушаалтан тодорхой хэргийн шийдвэртэй холбогдвол чиглэл өгдөг үү?

Сонсгол даргалагч П.Сайнзориг:

1/Аливаа гэмт хэрэгт холбогдсон иргэдийг нийгэмд урьдчилан цахимаар яллах буюу нотлох баримтууд эсхүл тодорхой хэргийн үйл баримтууд дээр авагдаж байсан баримтуудыг ерөнхийдөө нийгэмд цацчихсан байдаг. Хэдийгээр тухайн иргэн цагаадсан ч гэсэн энэ асуудлыг хэзээ ч арилахгүйгээр, гэр бүл, үр хүүхдээрээ давхар хохироод явдаг үзэгдэл байсаар байна. Тэгэхээр энэ дээр бодлогын түвшинд яаж шийдэх ёстой юм бэ?

2/Эрүү шүүлт хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбооны хувьд ямар нэгэн байдлаар эрүү шүүлтэд эсвэл хохирсон гэдэг нь шүүхээр шийдэгдчихсэн ийм 47 хүний кэйс байгаа юу? Маш олон жил явсан ч иргэний шүүх нь янз бүрийн хуульд заагаагүй үндэслэлээр нэхэмжлэлийг авахгүй, иргэдийг хохироогоод байна гэдэг зүйл яригдаж байна. Тэгэхээр энэ холбоонд нэгдсэн иргэдийн нийтлэг эрх ашиг яригдаж байна уу?

3/Засгийн газраас Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын хуулийг Улсын Их Хуралд өргөн барьсан ч парламент шинээр бүрдсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу буцаасан. Энэ хуулийг хэзээ өргөн барих гэж байна вэ? Мөн Гэр бүлийн тухай хуулийг хэзээ Улсын Их Хуралд өргөн барих гэж байна вэ? Гэр бүлийн тухай хуульд үрчлэлтээс эхлээд хүүхэд дагасан аливаа эрх зүйн үйлдлүүдийг шүүхээр шийдвэрлүүлье гэж байгаа юм.

4/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед зөвхөн биш бүх шатанд иргэн, захиргаа, эрүүгийн хэрэгт ч гэсэн нотлох баримтыг цуглуулахаасаа эхлээд эрх зүйн харилцааг тодорхойлох Нотлох баримтын тухай бие даасан хуультай болох бодлогын талаар Хууль зүй, дотоод хэргийн яам ямар байр суурьтай байгаа вэ?

5/Шүүх шинжилгээний асуудал маш том бүтэц. Эрүү шүүлт явахгүй гэвэл хэрэгт авагдсан цуглуулагдсан нотлох баримтуудыг маш хурдтай шинжлэх ухааны ололттойгоор шинжлэн магадалж дүгнэлтээ гаргах ёстой. Энэ асуудал нь шүүх шинжилгээний байгууллага дээр очоод тоног төхөөрөмж болон хүний нөөцөөс болоод гацдаг. Энэ асуудал дээр Засгийн газар цаашдаа ямар арга хэмжээ авах бодлого байгаа вэ? Ирэх жилийн төсөв дээр шүүх шинжилгээний байгууллагуудыг өндөр хүчин чадалтай лабораториор хангах асуудал байгаа юу?

6/Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвд хэвтэн эмчлүүлдэг байнгын байр суурьтай байгаа юу?

тодорхойгүй байна. Энэ асуудлаар төрийн бодлогыг цаашдаа яаж авч явах талаар Засгийн газрын байр суурь ямар байна вэ? Улсын ерөнхий прокурор, Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийгдэж байгаа үе шаттай ажлууд байна уу? зэрэг асуултыг асууж холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан болон сонсголд оролцогчдоос хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.1.6-д “*гишүүн оролцогчоос асуулт асууж, хариулт авч дууссаны дараа 5 минутад багтаан үг хэлж болно*” гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Цогтбаатар, Х.Баасанжаргал, Г.Ганбаатар, М.Нарантуяа-Нара, Ц.Сандаг-Очир, Да.Цогтбаатар, С.Эрдэнэболд, Ж.Баярмаа нарын нийт 9 гишүүн үг хэлэв.

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН НЭГДСЭН САНАЛ, ДҮГНЭЛТ

Хууль зүйн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” сэдвийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж, сонсголд Улсын Их Хурлын гишүүд болон оролцогчдоос гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн дараах байдлаар танилцуулж байна:

1. Хяналтын сонсголын үр дүн, хөндөгдсөн асуудлуудыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, сонсголоор хөндөгдсөн асуудлыг шийдвэрлэх арга замын талаар Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулах;

2. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн хохирлыг барагдуулах асуудлыг нарийвчлан зохицуулах үүднээс авлига, албан тушаал, ашиг сонирхлын гэмт хэргийн улмаас хураагдсан хөрөнгүүдийг хохирол барагдуулах ажиллагаанд зарцуулах, шүүхийн шийдвэр гарахаас өмнө учирсан ямар төрлийн хохирлуудыг тэргүүн ээлжид барагдуулж, буруутай этгээдээс гаргуулдаг байх зэрэгтэй холбоотой асуудлаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, дүгнэлт гаргах;

3. Эрүүдэн шүүхийн конвенцын орчуулга, агуулга нэр томъёог нэг мөр болгох, улмаар 2015 оны Эрүүгийн хуулийн “эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн шинжийг тодорхой болгох;

4. Засгийн газраас хүний эрхэд суурилсан, хүний эрхийн мэдрэмжтэй Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Гэр бүлийн тухай хуулийн төслийг боловсруулж, яаралтай Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх талаар чиглэл өгөх;

5. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг, үйл ажиллагааны талаар цогц судалгаа хийж, шаардлагатай тохиолдолд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлан шийдвэрлэх;

6. Шүүх шинжилгээний байгууллагын тоног төхөөрөмж, хүний нөөц, төсөв санхүүжилт, чиг үүргийн талаар Засгийн газраас бодлогын арга хэмжээ авах талаар чиглэл өгөх;

7. Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн эрхийн хамгаалах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг гадаад улс орнуудтай байгуулах, ялангуяа Монгол Улсын иргэд олноор амьдарч байгаа улс орны хувьд иргэдийнхээ амь нас, хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр Засгийн газраас бодлогын арга хэмжээ авах талаар чиглэл өгөх;


8. Эрүүдэн шүүх, хүнлэг бус хэрцгий хандах, хүний эрхийн чиглэлээрх судалгаа мэдээллийг холбогдох байгууллагууд нарийвчлан гаргах, улмаар холбогдох мэдээллийг Улсын Их Хурал, Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороонд ирүүлж, шаардлагатай тохиолдолд энэ төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдтэй хийх уулзалтыг тогтмол зохион байгуулах;

9. Албан үүргээ гүйцэтгэх явцдаа иргэдийг эрүүдэн шүүсэн, хүнлэг бус хэрцгий хандсан, хүний эрхийг зөрчсөн албан тушаалтны талаарх жагсаалт үүсгэх, Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагын арга хэмжээг чангатгах;

10. Мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд бие биесээ хянадаг, шалгадаг одоогийн бүтэц тогтолцоог өөрчлөх асуудлыг судлан, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах;

11. Улсын Их Хурлаас эрүүдэн шүүх, хүнлэг бус хэрцгий хандах, хүний эрхийн хэрэгжилтийн асуудлыг цогцоор хянан шалгах, санал, дүгнэлт гаргах шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллах зэрэг болно.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.ЦОГТБААТАР